

Байгаль – ертонц



Ховор амьдыг хамгаалахад чилэгдсэн сэтгэл, оюуны дархлааг хэрхэн бий болгох вэ, дэлхий дээрх уулын бvс нутгуудийн хvн амыг vнд хэрхэн оролцуулах вэ? Энэ вйл хэргийг хэний тусламжтайгаар зохион байгуулах боломжтой вэ? гэдгээс эхлээд, дэлхийн унаган, торолх шинж байдал, газар, газрын уугуулуудын уламжлалт соёлыг хамгаалах, орон нутгийн оршин суугчдын байгаль хамгаалах уламжлалт мэдлэгийг дамжуулан, овлvлэх гэх мэт олон асуудлыг олон улсын хэмжээнд цогцоор нь хэлэлцэнэ гэдэг бас ч нарийн товогтэй зvйл бололтой.

Саяхан Киргизстаны Таласс мужид дээрх асуудлаар, тодруулбал нэн ховор болон ховордсон амьтдыг хамгаалах сэдвээр тал бvрээс нь нарийн нухацтай хэлэлцсэн хэлэлцvлэг, семинарыг зохион байгуулсан бoгoод эл семинарт Киргизстан, Тажикстан, Уулын Алтай, Буриадын толоологчид оролцсон юм.

### **Ардын мэдлэг бол шинжлэх ухааны туйл**

Онгорсон жилvдэд “Дэлхийн зэрлэг амьтдыг хамгаалах сан”-гийн харъяа Орос дахь олон улсын зовлолоос “Алтай Саяны эко бvс дэх цасны барс (ирвэс) хамгаалах ажлын мониторинг” тослийг хэрэгжvлж, онгорсон хаврын тавдугаар сард ОХУ-ын Алтайн Бvгд Найрамдах улсын нутаг дэвсгэрт эл асуудлаарх экспертиз

(  
хяналт, шинжилгээ

)  
хийснээс гадна Орос, Монгол, Киргизстан, Казакстан, АНУ, Энэтхэг болон Хятадад

цасны барс буюу ирвэс хамгаалах туршилт судалгаанууд хийгджээ. Семинарт уригдсан зочдын дунд онцлууштай нэгэн хvн байсан нь “цасны барс” буюу ирвэс хамгаалах ажиллагааг

(Snow

Leopard

Conservancy),

анхлан эхлүүлсэн Жексон юм. Энэ хvн бол дэлхий дээрх ирвэсийн оршин амьдарч буй нутгуудад явагдаж буй ирвэсийн судалгааны ажлыг голлон удирдаж ирсэн хvн. Тvний хэлснээр “нутгийн уугуул иргэдийн соёл, зан заншил, уламжлалт дадлыг хvн амын дунд таниулах, ач холбогдол, нолооллийг нь оргон сурталчилах, ирвэсийн оршин амьдардаг бvс нутгууд дахь тосгон суурин, сум, багийн оршин суугчдын байгаль хамгаалах болон экологийн мэдлэгийг дээшлүүлэхэд тал бvрээр туслах явдал хамгаас чухал зvйлийн нэг” ажээ.

Цасны барсыг /ирвэс/ хамгаалах дэлхий нийтийг хамарсан хотолбор хэрэгжvлэх ажилдаа орон нутгийн иргэд олон нийтийг яаж татан оролцуулах ёстой вэ гэдэг их чухал. Родни Жексон хэлэхдээ “оноогийн ноцолд хотолбор маань нутгийн уугуул иргэд болон орон нутагт оршин амьдарч буй олон нийтээс хондий холуур явагдаад байна. Тэгэхээр хотолборийг ирвэсийн тархан амьдарч буй нутагт болоод тухайн нутаг усныхны аж амьдралд наалдуулж огоход vндсэн ач холбогдол нь орших учиртай. Энэ талын зvтгэлтнvд маань зовхон судлаачидтай хамтран ажиллах болоод байгаль хамгаалал, газар орны асуудлыг чухалчилаад байдаг. Харин бид бол энэ мэт хийдлийг арилгахыг хvсэж байна. Манай зорилго бол шинжлэх ухааны вйл явцыг ардын уламжлалт мэдлэг, зан заншилтай хослуулан нэгтгэх замаар ирвэсийн оршин амьдарч байгаа газар нутагт тvгээн дэлгэрвvлэх овормоц хэлбэрийг эрэлхийлэх явдал. Жишээлэхэд цасны барс

(  
ирвэс

)

-ийн тархан нутагшиж буй нутаг орны хvн амын 70 хувь нь буддизм, боо моргол, болон тvвтэй тостэй шvтлэгийг эрхэмлэн дээдэлдэг ард тvмнvд байна. Дэлхий дахин дахь байгаль хамгаалал, ховор ан амьтан хамгааллын бодлогод ийм чиглэлийн оюун санааны толоологчид ихээхэн чухал vврэг гvйцэтгэсэн байдаг. Ирвэсийг хамгаалах тухайд ч vvнийг ашиглах хэрэгтэй” гэсэн. Ардын ийм соёлын ов уламжлалыг

/

парактикт

/

хэрэгжvлж буй вйл ажиллагаандаа ашиглах зорилгоор Орос дахь “Олон улсын зовлол”-оос ирвэсийн тархан шилжиж буй болон нутагшин оршиж буй орнуудын тухайн эко бvсэд амьдардаг уугуул ардууд, оршин суугчид, нийгмийн нийтлэгvвдийн

(

мал аж ахуйн салбарынхан, анчид, нийгмийн бvлгvвд

)

сvлжээг Монгол, Киргизстан, Тажикстан, Алтайн Бvгд Найрамдах улс, Оросын Буриадыг

хамруулан үүсгэсэн. Үүнтэй холбогдуулж 2016 оны гуравдугаар сард Монгол улсын Тов аймагт зовлолдох уулзалт

/

семинар

/

зохион байгуулсан юм.

## **Амьтны тооллогын өрсөлдөөн**

Урьд нь мон энэ Талассын хондид үүнтэй тосоотэй сэдэв бүхий “тэнгэрийн амьтад”-ыг /н эн ховор зэрлэг амьтад

/

хамгаалах нь” сэдэвт зовлогоон, хэлэлцүүлэг болсон богоод эл үеэр ирвэсийг олон улсын түвшинд юу гэж нийтлэгээр нэрлэвэл зохих тухайд хэлэлцүүлэг орноход, уулан дахь ирвэсийн явдаг замтай холбоотойгоор нэр байж болох юм гэсэн санал дээр олонхоороо нэгдсэн. Яагаад гэвэл тэд “цасны барс”

(

ирвэсүүд

)

А бүхний түрүүнд хэцүү газраар явж

8

жим гаргадаг ба амьтад тэр жимээр нь явах боломжтой болдог байна. Хил дамнан уул нуруудыг хэжиж гаргасан тэрхүү зам нь магад торгоны их замын нэгэн хувилбар гэхүйц үлэмж хэмжээний газар нутгийг холбосон сүлжээ жимийг үүсгэсэн хэрэг. Оноодор ондор уулын махчин амьтдын тоо толгой цоороход зовхон хулгайн анчид гэлтгүй хүний янз бүрийн үйл ажиллагаа нолоолж байна.

Энэтхэг оронд гэхэд л аялал жуулчлалыг түрцтэй хөгжүүлснээр тэр нь зэрлэг амьтад тухайлбал ирвэсийн нутагшил байршилтанд аюул занал учруулж байгаа асуудал бий. Алтай, Ала Тоо, Памирын уулсуудын харьцангуй ондорлог түвшинд малчид нутаглан амьдрах нь элбэг, тэдний дийлэнх хэсэг нь ирвэсийн тархан амьдарч буй нутагтай давхцдаг. Үүний улмаас гэрийн тэжээвэр болон зэрлэг амьтдын хооронд орсолдоон, сорголдоон бий болох үзэгдэл ч гардаг байна.

Талассын нутаг дэвсгэр дэх “Ойн бүс нутгийн хамгаалалтын захиргаа”-ны ахлах мэргэжилтэн Акылбек Курманбаев хэлэхдээ “Зун эхэлмэгц малчид олноороо ууланд гарч нутаглах болдог. Тэгээд хамгаалалтын бүс нутгуудад

(

уулын

)

бэлчээрийн зовшоорол олж авах орсолдоон идэвхжинэ. Малчдад олгосон бэлчээрийн зовшоорлийн бичиг бүрийг тухайн газарт оршин амьдарч буй ирвэс болон бусад зэрлэг амьтдын дундаж тоо, толгойг тогтоох үүрэг дагалддаг. Тэд зовхон мал, хариулах малчин хоёроос гадна хамтран ажилладаг бүл “хамжлага”-уудтайгаа хамтдаа явахыг хичээдэг. Аргагүй тэдний аж амьдрал нь шvv дээ. Тvvнчилэн хамаатан садан, найз ноход гээд зочдоо урих явдал ч цоонгvй. Уригдсан зочид болоод тvvгээр зорчиж буй малчид тэр газарт ирвэстэй гэдгийг мэдсэн атлаа зовхон дотроо бодоод явахгvй нь мэдээж, гэр бүл найз ноход бусад хvмvvст энэ тухай ярина. Эцэстээ энэ байдал нь зарим хvмvvсийн хулгайн ан хийх, хууль бус орлого олох сэдлийг одоогч хvчин зvйл болдог. Тиймээс иймэрхvv холбоо сvлбээнээс vvдэлтэй хууль бус зvйлvvд явагдах бололцоог хазаарлахад анхаарлаа хандуулах шаардлага бас тулгарч байгаа юм. Тосгон, суурин болгонд “бэлчээрийн хороо” гэж бий тэр хороо энэ асуудлыг хариуцвал зохих юм.

Бас цасны барс (ирвэс) хамгаалах хотолборийг хэрэгжvvлэхдээ тэдэнтэй хамтран ажиллах нь нэн чухал. Оноодор дэлхий дээр хичнээн тоо, толгой цасны барс

/

ирвэс

/

оршин амьдарч буй нь тодорхой бус байна. Эрика Шукуровагийн

(

Киргизстан дахь

«Алейне Плюс»

экологийн ходолгооний тэргvvн

)

хэлснээр бол оноогийн байдлаар ирвэсний тоо, толгойг тогтоох нэгдсэн арга зvй бий болоогvй, Киргизстанд гэхэд л тодорхой тоо гарч ирээгvй байдаг. Ийм нохцол байдал дэлхийн бусад газруудад мон адил нийтлэг бий. Ирвэсийн тархан нутагшиж буй улс орон, бvс нутгуудад хаа ч ялгаагvй тухайн амьтны тоо толгойг ойролцоогоор багцаалж л тодорхойлж байгаа богоод баримжаалсан зороо нь

(

бодит болон бодит бусын хоорондох

)

ихэнхдээ араваас, зуугийн хооронд хэлбэлзэж байна гэсэн тойм бий. Хэрвээ бид тодорхой тоог нь тогтооё гэвэл зовхон ирвэсийг тусгайлан тоолох бус экосистемийн нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан, ирвэсийн амьдрах хvчин зvйлvvдийг нохцолдvvлэн, дэмжиж байгаа бусад амьтад хийгээд хоол, тэжээлийн баазынх нь тоо, хэмжээг цогцоор нь тоолж тогтоох хэрэгтэй болно” гэж байлаа. .

**Үр удам ба хэрцгийлэл**

Тарвага бол ирвэсний идэш тэжээлийн баазын нэг хэсэг болдог нь сонирхолтой. Энэ тухай семинар дээр Монгол улсын “Нүүдлийн байгаль хамгаалал” торийн бус байгууллагын (Буриад улсын гишүүн байгууллага) тэргүүн Тунгалагтуяа сонирхолтой зүйл ярьсан.

Тэр Монголын баруун аймгийн хоёр суманд нутгийн иргэдтэй хамтран судалгаа хийжээ. Энэ үеэр тарваганы маханд “хэт донтогсод” (дурлагсад) оороор хэлбэл ирвэсний идэш тэжээлийг булаагсад байдгийг мэдсэн байна. Есон сарын сүүлчээр тарвага ичээндээ ордог ба тэгмэгц арван сарын эхээр ичээ малтагсад ажлаа эхэлдэг байна. Судалгаа хийх явцад ийнхүү ичээ малтсан 30 гаруй тохиолдлыг олж мэджээ. Энэ үйлдлийн улмаас тарваганууд тэдний гарт бооноороо үрэгддэг. Тэд тарвагыг ийнхүү бүлээр нь хомроглон алах замаар хүнс бэлддэг ажээ. Нутгийн нэгэн малчин тарвагыг үүр нүхэнд нь нядлах энэ үйлдлийг хэрхэн, яаж хийдэг тухай ярьж огсон юм.

Эхлээд тэд томор ломбоор нүх буюу үүрийг нь ухаж цомлодог байна. Тарваганууд сандарч, айсандаа аюулаас гэтлэх гэж тэдний гаргасан уйтхан цоорхойгоор цувж, асгаралдан, алуулдаг гэнэ. Цоморхий цоохойны аман дээр аюул отож байгааг гадарлаж мэдсэн, үүр, нүхэндээ үлдсэн хэсэг нь нүхнийхээ мухар луу хяран зүтгэж, хуруу хумсаараа амь тэмцэн маажлан малтсаар, үүр нүх нь тэдний сарвуу хумсны цусанд будагдана. Ингэсээр хоорхий амьтад хамаг чадлаа барж, эсэргүүцэх, аюулаас зайлах чадалгүй болоод үүр, нүхэндээ бүгд үхдэг байна.

Би хэд, хэдэн сумын сургуулиуд айл орхвдээр явж, ялангуяа хvvхдvvдэд энэ тухай ярьж огсон. Үүнийг сонссон хvvмvvсийн нvднээс нулимс гарч байсан. Хvvхдvvд энэ тухай сонсоод “хэзээ ч тэр хоорхий амьтны махыг идэх гэж ийм юм хийхгvй, хэзээ ч амьтдыг харгислаж зовоохгvй” гэцгээж байсан юм” гэж ярив.

Эцэст нь Тунгаа хэлэхдээ “миний бодлоор судлаачид судалгааныхаа бодит үр дvнг хvvмvvст, ялангуяа хvvхэд өсвөр вейнхэнд танилцуулж, ойлгуулж, хэлж огч байх хэрэгтэй юм байна. Тэгвэл энэ нь хvvмvvст, хvvхдvvдэд байгалийг, бас амьтадыг хайрлах, хамгаалах бодол ухааныг торvvлж, толовшvvлэх, цаашдаа экологийн зов ойлголт, сэтгэлгээтэй болоход нь ихээхэн нолоотэй байх болно” гэсэн юм.

**Тэнгэрийн амьтан зочилсон нь**

Монгол улсын Ховд аймгийн Дарви сумын Дагвадорж гэдэг ахмадынх ууланд ирвэсийн тархац газартай хаяа нийлэн нутагладаг аж. Энэ хvн сургуулийн хvvхдvvдтэй уулзалт хийж, ирвэсийн тухай, тvvний нутаг байршил болон ирвэстэй холбоотой ардын ёс уламжлалын тухай ярьж огчээ. Монголд цасны барсыг ууланд амьдардаг амьтдын сvр сvлд, сvр хvчний бэлэгдэл хэмээн сvсэглэж ханддаг байна. Ууланд малчдын нутагладаг газар ирвэс байх нь элбэг богоод малчид тvvнд ойртдоггvй. Тvvнээс айж болгоомжилдоггvй, дайжиж зугатдаггvй, хоож туудаггvй харин ирвэс vзсэн хvн ихэд бэлэгшээж сvv оргон мялаадаг аж. Тэрээр ирвэстэй тааралдвал тэр хvний зам мор нь цагаан, ажил vйлс нь бvтэмжтэй болно гэж бэлэгшээдэг гэнэ.

2014 онд Дагвадорж гуайнхтай хошоо (ойрхон) нутаглаж байсан малчныд нэг ийм явдал тохиолджээ. Нэг орой бэлчээрээс гэртээ дохож ирсэн мал нь vргээд хотондоо орохгvй байхаар нь гэрийн эзэд гайхаж, ийш тийш ажиглан харвал, тэдний гэр дээр нь ирвэсний ногуул (зулзага) гараад цагираглаад хэвтчихсэн, ууттай махны гадна талаас мэргэж байж. Тэд тэвдэж, сандарсандаа гэртээ орж чадахгvй, улмаар сумын тов рvv утасдажээ. Сумын удирдлага vвнийг сонсоод, тэдэнд туслахаар ирэх замдаа Дагвадорж гуайг хамт авч явсан аж. Тэд ногуулыг гэр дээрээс буулгахын тулд бугуйл

(  
цалам

)  
аваад, малчны гадна очив. Харин гэрийн эзэн малчин “манай гэр дээр тэнгэрийн амьтан мориллоо” хэмээн ихэд бэлгэшээж, тvvнийг гэр дээрээс буулгахын омно том тэвшинд хэсэг

мах, мон ёроолд нь сvv асгаж,

(  
хийж

)  
бэлджээ.

Дараа нь ирвэсний ногуулыг (зулзага) цалмаар цаламдаж, моноох тэвшрvv татаж буулгахад ногуул тэвшинд буй махыг идээд, сvvг тааламжтай гэгч нь долоож эхэлжээ. Тэгээд тvvнийг хоёр уут махтай хамт ууланд нь аваачиж тавьсан байна. Учир нь тэр мах идэх гэж л малчин айлд зочилсон. Тэгэхээр тvvнийг ууланд нь тавихдаа махаар дайлах нь зvй ёсны хэрэг. Дараа нь оноох газарт очиж vзэхэд ногуул “цасны барсхан” маань бусдыгаа дагуулан, мах идэхээр хавцлаар бууж ирсээр, нэгэнтээ тэдний явдаг жим бий болсон байв. Гэр дээрээс буулгаж авсан хvmvсийн гараас чолоологдож, ууланд очсоныхоо бvvр хойно ч гэсэн тэр ногуул “барсхан” маань махны vнэрээр ирэхээ орхиогvй богоод цадаж, аваад ууландаа харайж, дvvлж оддог болжээ. Тэр жилдээ болоод тvvнээс хойш ч ялгаагvй тэр малчны мал сvрэг

нь улам осож, арвижин элбэг, чинээлэг болсон богоод тэрхvv уут магнаас болж хотойж, хорогдсон нь vгvй.

“Эрт veэс манай овог дээдэс ирвэсэнд ош зангидаж болдогvй гэж vздэг байсан. Хэрвээ ирвэс хонь, маланд хvрсэн бол харин ч бэлгэшээж, зонгоор нь орхивол, мал ахуй нь улам осож vржиж, элбэг дэлбэг болдог, харин осорхож тvvний хойноос хооцолдон намнах аваас айл хотоороо сvйрч доройтдог тухай сvсэглэн хэлэлцдэг байсан. Энэ миний ярьсан бол бодит тvvх, би оороо оролцож, нvдээрээ vзсэн явдал билээ” гэж Дагвадорж гуай ярьсан байна.



### Памирчууд ба ариун амьтан

Тажикстаны Хорог хотоос ирсэн сэтгvvлч, экологич Курбон Аламшоев ярихдаа: “Манай хот бол “Бадахшанск” уулын автономит мужийн тов нь богоод далайн тvвшнээс дээш 2000 гаруй метрт оргогдсон ондорлог хэсэгт оршдог. Ард, иргэд маань мон л цасны барс

(  
ирвэс

)

-ын байршил нутагтай хаяа залгаж, холилдон нийлж аж тордог юм. Цасны барс буюу ирвэсийг Тажикаар Пуланг гэж нэрэлдэг. Гурван жилийн омно бид

"Куххои Помир", (  
Уулын Памир

)

олон нийтийн байгууллагыг vвсгэн байгуулсан. Үvнийхээ хvрээнд хотын дорвон сургууль дээр экологийн клуб нээн ажиллуулж байгаа. Энд би

Сайфиддин Шайдоев

болон

Курбонбек Айдаров

гэдэг тус клубын хоёр ч удирдах ажилтны хамт хvрэлцэн ирсэн юм гэв.

Курбонбека бол Мургабск мужийн Ранкуль тосгоны уугуул, Киргиз үндэстэн аж. Энэ семинарт ирсэн хүмүүсийн хамгийн залуу нь болох тэр Памирын Киргиз тосгоны нэгэн дунд сургуульд Тажик хэл заадаг. Тэрээр ахмадуудын хэлж ярьсан болгоныг үг гээлгүй шимтэн анхаарч, үнэн голоосоо санал нэгдэн дэмжиж байв. Одоо вед замхран мартагдах шахаж буй, тэрхүү Монгол настаны ярьсан шиг амьд түүхийг бид хадгалж хамгаалах ёстой хэмээн тэр хэлнэ. Түүний амьдардаг Памир ууланд далайн товшноос дээш дорвон мянга гаруй метрт оргогдсон газарт нэгэн тосгон байдаг ба оороо тэнд хэд хэдэн удаа очиж, цасны барс (ирвэс)-тэй ч

тааралдажээ. Харамсалтай нь тэр ведээ ямар ч зураг авч, бичлэг хийж чадаагүй гэнэ. “Тэндхийн хүмүүс ийм зүйлийг хэрэглэж заншаагүй нь тоогүй. Уул нь хэрэглэдэгсэн бол амьдралд хэрэгтэй л зүйл. Цасны барс

(  
ирвэс

)  
гэдэг чинь тэр чигээрээ байгалийн дурсгал, үзэсгэлэн юм” гэж тэр ярина. Тэрээр Ишкашимск

мужийн  
Шитхарв

тосгоноос ирсэн мэргэжил нэгт,

(  
тажик хэл, уран зохиолын багш

)  
Сайфиддин Шайдоев

ээс ондор уулын цасан дунд амьдардаг амьтад болоод цасны барс

(  
ирвэс

)  
-тэй холбоотой олон сонин түүх домог сонсож авчээ.

“Манай тэнд хүүхдүүд болон освор веийнхэнд байгаль хамгааллын тухай, бас цасны барс

(  
ирвэс

)  
-ийг хамгаалах тухай ойлголт мэдлэг огох талаар бага биш зүйл хийгддэг. Бид хүүхдүүдээс олон домог үлгэр цуглуулж авдаг. Манай нутгийн уугуул хүмүүс ирвэсийг бараг ид шидийн амьтан гэж домоглодог юм билээ. Ийм нэгэн түүх байна л даа” хэмээн тэр Памир нутгийн сонирхолтой түүхийг ярив.

“Нэгэн гороочин уулын хавцал дахь нарийн жимээр явж одсон зэрлэг гороосний хойноос хоож явсаар хаашаа ч гарах аргагүй, ганц хүн л явах боломжтой хавчиг, уйтхан зорог рүү



шургажээ. Гэтэл яг тэр хэсэг дээр нэг барс (ирвэс) гарч ирээд омоос нь тулах нь тэр. Гороочин ч ирвэс ч ялгаагүй, аль, аль нь тэр нарийн хавцал зоргоос гарах юм бол уулын хавцал руу нисэх зам л хвлээж байв. Тэд оод, оодоосоо ширтэлцэжээ. Гороочин буугаа газар тавиад, ирвэсэнд хандан “чи ч, би ч адилхан, бид хоёулаа анчид шvv дээ. Хэн, хэндээ саад болохгүйгээр алтан дэлхий дээр мор, мороо хоож явъя л даа” хэмээн “уулын эзэн”-ээс царайчлан гуйжээ.

Тэгтэл моноох ирвэс гороочнийг ойлгож, хажуу тийш огло всрэн, нэгэн хадан дээр гармагц, хадны завсар, зайгаас сарвуугаараа зууран тогтож байв гэнэ. Гороочнийг онгорvлэхийн тулд тэр ийнхvv зам чолоолж огчээ. Тvvнээс хойш хэдэн жил онгороход энэ тvvхийг мартсан бас нэгэн анчин тэр зам дээр ирвэс явахыг харангуут буугаа онилон, буудаж орхисонд ирвэс цохронгvй байдлаар эхэр татан орилоод хавцал руу нисэж vxжээ. Анчин ч ирвэсийг бахархалтайгаар буудаж алав хэмээн бардамнан сайрхаад, цааш одсон богоод vvнийг нь сонссон ахмад гороочин тvvнд “чи ч тун тусгvй юм хийж дээ. Уулын амьтантай тэр тусмаа ирвэстэй харьцахдаа байнга хvндэтгэлтэй харьцах хэрэгтэй. Зам дээр чинь хэрэв ирвэс таарсан бол чи зам зайлж огох нь зов байсан” гэж хэлжээ. Тодолгvй ирвэс буудаж алсан оноох анчин vгээгvй ядуурч, ангийн тэнгэр нь хаяснаар барахгvй, сайныг vзэлгvй байсаар насан эцэслэсэн байна. Харин тэр анчны эцэг нь энэ явдлын тухай ихэд харамсан, оорт тохиолдсон зvйл юм шиг л хойчийн хvmvвст сургамжлан ярьсаар оноо ved хvргэжээ. Энэ бол домог vлгэр биш онгорсон зууны доч, тавиад оны ved хорш тосгоны маань хvmvвст тохиолдсон бодит vйл явдал” хэмээн хvvрнэв. Памирчууд муурыг гомдоохыг цээрэлдэг богоод хэдийнээс тvvнийг ариун амьтан гэж vзсээр иржээ. Тэрээр муур vxсэн бол “алтан хальс нь дvvрлээ” гэж хэлдэг, энэ нь амьдрах хугацаа нь хумигдаж, хязгаарлагдав гэсэн утгатай богоод, vvний толоо удаан гашууддаг заншилтай аж. Нутгийнхны дунд энэ зан vйл /харилцаа/ одоо хvртэл хадгалаг дсаар байна. Урьд veийн ийм амьд тvvхvvд бvгд цасны барс

(  
ирвэс  
)

-ний ойр, хамт нутагладаг нутаг орны ард тvmний дунд бий болж, хадгалагдан оноог хvрсэн ба амьтаны vхлээр баяжих сонирхол оворлодог зарим хvmvвст нэн хэрэгтэй зvйл билээ.

“Ирвэс (цасны барс) хамгаалах хотолбор”-ийн (Snow Leopard Conservancy) боловсрол хариуцсан захирал

Дарлы Хиллард

ын бодлоор цасны барсыг хамгаалахын тулд бид ардын энэ мэдлэг, ухааныг давхар хамгаалж байж vр дvнд хvрэх ёстой. Дарлы бас хэлэхдээ “энд бид боогийн ёстой холбоотой, ариун газар орныг сахин хамгаалах нарийн, ширийн зvйлvvдийг хондох боломжгvй байна. Яагаад гэвэл одоо энэ мэдлэг, ухаан нийтийн тvvшинд vндсэндээ мартагдсан, маш ховор зvйл учир боо нараас оор мэдэх хvн бараг vгvй юм. Харин дээр яригдсан ардын мэдлэг, ухаан маань малчид, ходоогийн сэхээтнvvд багш нар, орон

нутгийн байгаль хамгаалагчид болон байгаль хамгааллын чиглэлийн зарим мэргэжилтнүүдэд оочин цоочин дамжин уламжлагдажээ. Тэгэхээр бидэнд ардын ийм ов мэдлэгийг улам баяжуулан хадгалахад нь нутгийн уугуул иргэдэд туслах замаар хүрээлэн байгаа орчноо хамгаалах, хуучны овийг дэлхий нийтийн түвшинд сэргээх найдвар байна гэсэн үг. Бас цасны барсууд

(  
ирвэсүүд  
)

-ийн гаргасан “торгоны зам” зам бол хил хязгаар гэдэг зүйлд хамаарахгүй, хилийн шугамаар таслагдах учиргүй зам юм” хэмээн үгүүлсэн.

Семинар хэлэлцүүлгийн эцэст тов азийн орнууд дахь шинэ сонирхогч гишүүд, цасны барс (ирвэс)-ний оршин амьдардаг орон нутаг дахь олон нийт, уугуул ардуудыг татан оролцуулах замаар “газар дэлхий дээрх цасны барсыг хамгаалах” сүлжээг оргожүүлэн, хүчжүүлэх ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэв. Орон нутаг дахь залуучууд, сургуулийн хүүхдүүд өсвөр үеийнхний экологийн мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхэд чиглэгдсэн торол бүрийн үйл ажиллагаа явуулах, нэн ялангуяа цасны барсын оршин амьдарч буй гол хэсгүүдийн дунд, буй хулгайн анчид, хууль бус ажиллагаа явуулагчдад ийм аргаар хүчтэй нолоолох нь нэн шаардлагатай гэдгийг тэмдэглэв. Онцлох газар нутгуудыг торол бүрийн түвшинд баталгаажуулсан хамгаалалтын бүс, тойргоос гаргахгүй байх. Тэдгээр газар нутгуудыг, байгаль хамгааллын хориг, зарчимуудыг албан ёсоор сахиж мордох журам үйлчилж буй, сүлжээнд хамрагдсан, хамгаалалттай газруудтай коридороор

(  
суваг, хоолой  
)  
холбох.

Энэхүү үйл ажиллагаанд техник технологийн орчин үеийн ололт дэвшлүүдийг (фото хэрэгсэл, видео камер, компьютерийн программууд болон бусад боломжууд

)  
ÂÂ

нэвтрүүлж, суурилуулах. Ардын уламжлалт мэдлэг, зан заншил, хуримтлуулсан туршлага зэрэг чухал мэдээллүүдийг хоорондоо солилцох мэдээлэл солилцооны эрчимтэй арга хэлбэрүүдийг шуурхай нэвтрүүлэх. Ховор болон ховордсон амьтад түвчлэн бусад амьтадын нутагшил газар, эко системийн хүрээнд гарч буй хууль бус зүйлүүд, хулгайн ан агнуур зэрэг зорчлийн мэдээллийг цаг алдалгүй мэдэж, орон нутгийн олон нийт, мэдээлэл хүргэх шаардлагатай бүсүүдэд дамжуулдаг байх бололцоог бүрдүүлэх гэсэн шийдлүүд дээр мон санал нэгдэв.

Семинарт оролцсон бүх улс, орнууд болон бүс нутгийн толоологчид нэгэн шийдвэрийг

маш хангалууг хвлээн авч дэмжсэн нь “Цасны барс олон улсын форум”-ыг ирэх наймдугаар сарын сүүлчээр Киргизстаны нийслэл Бишкек хотод зохион байгуулахаар болсон явдал байв. Уг форумыг “Цасны барсыг хамгаалах мониторингийн вйл ажиллагаанд орон нутгийн уугуул иргэд болон олон нийтийн оролцоог эрчимжүүлэх нь” сэдвийн дор зохион явуулахаар болсон юм. Тvvнчилэн цасны барс болон тvvний оршин амьдах эко системийг хамгаалах дэлхийчилсэн хотолборийн хврээнд, 2020 он гэхэд vндсэн 20 эко системийг бvрдvүлж буй 12 орны нутаг дэвсгэр дээрх цасны барс (ирвэс)-ийн тоо толгойг 100-аар олшруулсан<sup>1</sup> байх зорилт дэвшvүлэв.

### **Форум (зөвлөлдөх уулзалт)-ын хврээнд**

Талассын хондид болсон энэхvв семинар хэлэлцvүлэг цасны барс (ирвэс)-ийг хамгаалах тухай нарийн, тvвэгтэй асуудал хэлэлцэхээс гадна оор ч олон сонирхолтой зvйлvүдээр элбэг байв. “Алтайн тогтвортой хогжил” сангийн дарга Чагат Алмашев намайг энэ семинарт урьсан юм. Ийм чухал богоод сонирхолтой семинар, аялалд би бvүр оороо оролцож амжихгvй нь гэж байсныг яана гээч.

Бид Бишкек хотоос ходолсноос хойш Серпантиний хондийгоор давхисаар, хоёр одрийн дараа гэхэд далайн товшноос дээш 3125 м оргогдсон Тоо Ашуугийн даваа мон 3326 метрийн ондорт байх

Отмок

ийн давааг давж гарлаа. Тэгээд Таласс муж дахь

Сусамыр

ын хондий рvү явж орчихсон юм. Зам маань Талассын

Бакай-Атинск

ын районы

Осгоруш

сууринд хvрч зогсов. Тэнд бид Бай-Болын ажиллаж, амьдарч байсан “угсаатны оргоо”-нд зочлов. Семинарт оролцогсод Киргизийн vндэсний цогцолбор болох Манас ордонд байрлаж, зовлолдсон богоод энэ бол Киргизийн нэгдэл нягтрал, баатарлагын бэлгэдэл болсон туульсын гол баатар Манасын нэрээр нэрлэгдсэн цогцолбор билээ. Тэрчилэн “Беш таш” байгалийн паркад зочилон зургаа татуулж, «Каныкейапа»

-д мороо vлдээгээд одсон ирвэсний мороор замнаж, эрт цагт Манас баатрыг болон тvvний гэргий Каныкейг эмчлэн эдгэрvүлсэн гэгдэх “Око земли” рашаан уснаа хvрч тvvнээс хvртэв. Талассын хондий ч бас ийм баатарлаг домог тvvхтэй юм.

Бас нэг бахархууштай зvйл гэвэл дэлхийн дансанд алдраа дуурьсгасан, нэрт зохиолч

Чингис Айтматовын мэндэлсэн Хар буурын “Кара Бууринск” районы Шекер суурин тэндээс тун холгвй бий. Надтай хамт АБНУ-ын Эдийн засаг, аялал жуулчлалын хогжлийн сайд Светлана Владимировна Буйдышева, Соёлын яамны сайд асан Наталья Каруевна Саймина нар явсан богоод тэд маань Киргизын Таласс мужийн хвндэт иргэн болсноос гадна Алтайн бвгд найрамдах улсын Алтайн их сургуульд жил бвр Киргиз улсаас оюутан элсввлэн суралцуулах тухай гэрээнд гарын всэг зурав. Одоогийн байдлаар шинээр элсэгчид болон суралцаж буй оюутнуудыг нийлввлсэн тоогоор тус их сургуульд Киргизээс 300 гаруй оюутан суралцахаар болоод байгаа юм. Мон энд алдарт “Таласс” дууг зохиогч, нэрт хогжмийн зохиолч

Шекербека Шеркулова

гийн ач хvv Бакыттай уулзсан уулзалт сонирхолтой байлаа. Бакыт бол Талассын Ойн бvсийн хамгаалалтын захиргааны экологчоор ажилладаг. Тэр мэргэжлийн хогжимчин биш боловч, Киргизын ардын хогжим болох комуз хогжмоор хэнийг ч “ангайлгамаар” гайхалтай чадварлаг тоглоно. Бvх дэлхийн нvдэлч тvмний урлагийн

II

их наадамд мянган “комузист”-ын

(

комуз хогжмоор хогжимдогч хогжимчид

)

хамт оролцон,

«Маш ботой»

хэмээх гайхамшигт аялгууг чадварлаг хогжимдож, олны талархал хвлээжээ.Â

Таласст болсон энэхvv сонирхолтой аялал, семинар хэлэлцввлгийг зохион байгуулах ажилд

«Таалим-Форум»

сангийн зохион байгуулагч

Алмагуль Осмоновой

, “Ходоогийн хогжил” сангийн тэргvн

Кулуйпе Акматовой

,

эколог

ич

Акылбеку Курманбаев

нар голлон хvчин зvтгэсэн богоод тов ази дахь “био соёл”-ыг хамгаалах чиглэлээр явагдаж буй торол бvрийн вйл ажмллагааг олон жилийн турш тууштай дэмжиж ирсэн “

Кристенсенев

сан”-гийн тэргvн

Эржен Хамаганов

мон голлон дэмжигч, зохион байгуулагч нь байсан юм.

**Любовь ИВАШКИНА**

**Орчуулсан Хиргис Г.ТӨРМӨНХ**